

Б.АЗЗАЯА*

ТАЙХАР ЧУЛУУНЫ РУНИ БИЧЭЭС

Архангай аймгийн Ихтамир сумын нутагт орших Тайхар чулуунаа руни, согд, уйгур, монгол, дөрвөлжин, төвд, ланз, манж, тод, нангиад зэрэг арав гаруй зүйл үсэг бичгийн 200-аад дурсгал буй. Үсэг бичгийн эдгээр дурсгалаас хамгийн эрт үед холбогдох нь руни бичгийн дурсгал билээ.

Төв Азиас олдсон руни бичгийн нийт дурсгалаас Тайхар чулууны бичээс нь Түрэгийн хаант улс болон Уйгурын үед холбогдох цор ганц бэхэн бичээс гэдгээрээ онцлогтой юм. Учир нь Монгол болоод Енисей, Кыргыз, Таласаас хадан дээр бэхээр бичсэн руни бичгийн дурсгал олдоогүй билээ. Харин Хар Хожа хотоос олдсон цаасан дээр бичигдсэн руни бичгийн дурсгал буй.

Тайхар чулууны бэхэн бичээс нь нүүдэлчид дан ганц чулуун дээр бус тухайн үед бэх, цаасыг өргөн ашиглаж байсны нэгэн баримт нуталгаа хэмээн үзэх үндэстэй юм. Он цагийн хувьд Тайхарын руни бичээс Түрэгийн хаант улс болон Уйгур улсын эхэн үед холбогдох нь бичээсийн агуулга, үсэг зурлагын тиг хэлбэрээс тодорхой байна.

744-745 оны үед төр улсаа байгуулсан Уйгурууд 760-аад оны дунд үеэс согд үсэгт суурилсан уйгур бичиг зохион төрийн бичиг болгосноор руни бичиг мартагдаж эхэлсэн гэж судлаачид үздэг. Ялангуяа Уйгурууд Маанийн шашинд орсноор Бурхан шашны ном зохиол орчуулж эхэлсэн төдийгүй, руни болоод уйгур бичгийн бусад дурсгалуудад шашны холбогдолт сэдэв зонхилох болсон байдаг. Жишээ нь: Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт орших Арханангийн бичээс, Хангидайн хадны бичээс зэрэг¹ Уйгурын үед холбогдох руни бичгийн дурсгалуудад 𐰽𐰺𐰍 𐰽𐰺𐰎 /qutluγ bolzun - өлзий болтугай/ гэх ерөөлийн үгс тохиолдож байна. Үүнээс үндэслэн Тайхар чулуунаа буй аян замын ерөөлийн шинжтэй үгс Уйгурын үед бичигдсэн байх боломжтой юм.

Тайхар чулууны руни бичээсийг В.В.Радловоор удирдуулсан шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд ажилласан Д.А.Клеменц анх хуулбарлан авч “Хойд Тамирын бичээс” хэмээн нэрлэснээс хойш түүний судалгаанд тулгуурлан эрдэмтэд уншиж судалсан байна. Уул бичээсийг хамгийн анх В.В.Радлов тайлж уншсан² ба түүний уншлага, нийтлүүлсэн эхэд тулгуурлан Туркийн эрдэмтэн Х.Н.Орхун орчин цагийн турк хэлнээ орчуулжээ³. Хожим С.Е.Малов өмнөх хуулбар эхэд тулгуурлан дахин нягтлан галиглаж орос хэлнээ орчуулсан⁴ ажээ.

* МУИС-ийн ГХСС-ийн Түрэг судлалын тэнхимийн багш

¹ Ц.Баттулга, Монголын руни бичгийн бага дурсгалууд, Тэргүүн дэвтэр, -CORPUS SCRIPTORUM, Tom.I, Улаанбаатар, 2005, тал. 115-121.

² Radloff W, Die alttürkischen inschriften der Mongolei, Osnabrück, 1987, pp.260-268.

³ Orhun H.N, Eski Türk yazitlari II, İstanbul, 1938, ss.107-123.

⁴ Малов С.Е, Памятники древнетюркской письменности Монголии и Киргизии. М.-Л., 1959, стр. 46-54

Академич Б.Ринчен өөрийнхөө бүтээлд Тайхар чулууны бичээсийн гэрэл зургийг нийтлүүлжээ¹. Нэрт түүхч Х.Пэрлээ гуай “Тайхир чулуу” хэмээх тусгай товхимолдоо руни бичээсүүдийг хэвлүүлсэн бөгөөд тэрхүү хуулбар нь өмнөх хуулбаруудаас нилээд зөрүүтэй² байдаг. Түрэг судлаач С.Харжаубай Туркийн эрдэмтэн О.Ф.Серткаяагийн хамт дахин нягтлаж хэвлүүлсэн³ нь Тайхар чулууны руни бичээсийн талаарх сүүлийн судалгаа болно.

Бид эл өгүүлэлдээ Тайхар чулуунаа руни бичээс хэд байгааг тодорхойлохыг эрмэлзсэн бөгөөд учир нь судлаачид энэ талаар харилцан адилгүй санал дэвшүүлсэн байдаг билээ. Тайхар чулууны нийт бичээс он цагийн уртад нар салхи, цас борооны усанд элэгдэж муудсанаас гадна ухвар мөчид хүмүүсийн гарт ихээхэн өртөж сүйджээ. Иймд үсэг бичгийн энэ гайхамшигт дурсгал сүйдэж эрдэмтэн судлаачид түүнээ байх дурсгалыг нарийвчлан судлах бараг боломжгүй болсон байна.

Бид хээрийн судалгааны ажлаар тухайлан хэд хэдэн удаа зорин очиж ахин дахин нягталсан бөгөөд өөрсдийн хийсэн гар хуулбартаа тулгуурлан доорх орчуулгыг үйлдэж бусад эрдэмтдийнхтэй харьцуулан үзүүлэв. Энэхүү судалгаа зэсгийн биш бөгөөд эрдэмтэд дахин нягтлан судлахад хэрэг болох буй за хэмээн санана.

Дээрх эрдэмтдийн судалгаанд огт ороогүй нэлээд хэдэн бичээс шинээр олдсон бөгөөд харамсалтай нь зарим үсэг тэмдэгт арилж баларсан зэргээс үүдэн бүрэн утга илэрхийлэх бичээс тун бага байна. Тэдгээр бичээсүүдийг толилуулбал:

	Гар хуулбар	Үсгийн галиг
1.	<p> </p>	<p> bičin YiL Qa WY... Q... Dmz y.r.. </p>
2.	<p> </p>	<p> yrda YWL bi... ...m yrm... kök ... tngri YWL Tngr Isi Q...R t BW...z </p>
3.	<p> </p>	<p> bg...TS péWR ...i...bY...ma...bitüm ...ilgibe...N bi...TGY...R... </p>
4.	<p> </p>	<p>YtkēBQTWN</p>
5.	<p> </p>	<p> aQ...mz Q...YRLQzWN ...msirka... </p>
6.	<p> </p>	<p> ...a... ...lgd: </p>

¹ Rintchen, Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, CSM. Tom XVI. Fasc 1, Ulaanbaatar, 1968, pp.34-36.

² Пэрлээ Х, Тайхир чулуу, Studia Archaeologica, том I, Fasc IV, Улаанбаатар, 1960, тал. 1-26

³ Sertkaya O.F, Harcavbay S, Hoyto Tamir (Mogolistan)dan yeni yazitlar (ön neşir), //Türk Dili Araştırmaları Yıllığı Belleten 2000, Ankara, 2001, ss.313-346.

7.	YrG	
8.	...gl...	...JE...
9.	...ja. ...GW:WLW szi...	...J... YJ>Y... ...Hh
10.	am:...ant ...yiiQ ...YyiQa	:OJ... :>J HYT9..... :YH9D.....
11.	...r.a... ...ng... ...Wg...L...J... Y...EY... ...Y>...J...
12.	tk... TiN:... yitnč... tür...	...h ...)T8 ...>hT9 ...YHh
13.	k... yp...	...J ...19
14.	Y... Bzy...	...D ...9H8
15.	Yti d tszir r....	...Y YTHhX TH9
16.	...irm rir pdrm	»YxY YTY »YT...
17.	YbZYL: ...tdm... ...rt...	:JDH8D ...>Xh... ...hY...
18.	Bjr mR... Q....	...H» YT8H
19.	i rsY...	...DHY T
20.	T irmbirGi...	...YTYT8»YT 8
21.	GL.....JE
22.	g...E
23.	...šid... ...i gi... ...Ti	...XTY... ...JE T... T8...
24.	T Gm...Bilnt WRLWYRGW:bitdm: k k: čWIN:m... WT Rnč Rp:BWY	OYT8...»Y 8 :»XhT8>YHDJH> ...»Y>L:Y Y D>S:1H >H 8>
25.L ...lgn L	J..... J JEY...

В.В.Радлов	<p>пачин жыл јатгич ай јагирма ...табчакка (?) бартык жылка токсыныч ай кушуу кара башык бастым күүттә табчакта (?) өлгүмиз адгү анча... сүлөп жарымазун...</p> <p>ҮҮҮҮДЭ...НЭ:ДННЛМ ХАҢС:ДННЛСА... ФНУУ:ЛСАДНННН:ФАИС:УУУУНННН:УИДННН:АТННН ННН:ФННННННН...ДНННХ</p>	<p>им Affenjahre, im fünften Monate... ...gingest du zu den Chinesen (?)... im Jahre, im neunten Monate... drückte ich nieder die schwarzen Köpfe, im Frühling starben wir bei den Chinesen... so viele Gute... mit dem Heere ausziehend möge er nicht leuchten (?)...</p>	
С.Е.Малов	<p>ҮҮҮҮДЭ(П)ННДННЛТХ ХАҢС:ДННЛСА... :ХУУУНННД:УИДННН:АТННН ФНУУ:ЛСАДНННН:ФАИД ННН:ФННННННН...ДНННХ</p>	<p>Бичин жыл јат(и)нч ай јагир(ма)... (...јаг...к) Табчакка бартык... жылка токсынч ай Кушуу кара башык жолтым күүттә Табчак(ла) (-ка) сүлөтүм. адгү ынча мунгүмү сүлөп жорымазун күлкүшу јры</p>	<p>В год Обезьяны, седьмого месяца, в двадцатый (день), Ты ходил в Табчаг, В год ... в девятый месяц, в (на?) Жушуе я добыл рабов. Осенью я пошел с войском на Табчаг (на Китай?) Хорошо так ... пусть не ходять в военные походы.</p>
Билд	<p>ФНУУ:ЛСАДНННН:ФАИС:УУУУНННН:УИДННН:АТННН :ХУУУНННД:УИДННН:АТННН :ФАИД:ХУУУНННН:УУУ :ФННННН:УУУУННН:ДНННН :ННН:ФННННННН:УУУУ ↓НННД:УУУУННН</p>	<p>Бичин жил долоо...хорин нэг Хоёр Гэчиг Бачагт Байтаг Таван...сар хар толгойд зуншив, би Намар Таниян чулуунаа чимээ илгээв. Зүдэрсэн цэрэгтээ явж хүрнэ, би. Өлөржингөө энэ гэрэлт санаа /бодол/...</p>	<p>Бичин жил долоо...хорин нэг Хоёр Гэчиг Бачагт Байтаг Таван...сар хар толгойд зуншив, би Намар Таниян чулуунаа чимээ илгээв. Зүдэрсэн цэрэгтээ явж хүрнэ, би. Өлөржингөө энэ гэрэлт санаа /бодол/...</p>